

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

01

Хөдөлмөр эрхлэлтийн
нийтлэг үйлчилгээ

02

Хөдөлмөрт бэлтгэх сургалтын
үйл ажиллагаа

03

Санхүүгийн дэмжлэг үзүүлэх
үйл ажиллагаа

04

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр
эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа

05

Түр ажлын байрыг дэмжих үйл
ажиллагаа

06

Засгийн газраас болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний
зөвлөлийн шийдвэрийн дагуу хөдөлмөр эрхлэлтийг
нэмэгдүүлэх үйлчилгээ, арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийг
холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулж,
хэрэгжүүлэн хяналт тавьж ажиллана.

01

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

01

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ

02

Ажилд зуучлах

03

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээ

02

ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

01

Суурь ур чадварын сургалт

02

Танхимын болон үйлдвэрлэл дээрх мэргэжлийн сургалт

03

Аж ахуй эрхлэлтийн сургалт

04

Залуучуудын сургалт, зөвлөгөө

05

Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалт



Ажлын байр

Ажил олгогч

Төсөл хөтөлбөр

**Та өөрт тохирох
ажлын байр,
ажилтнаа
эндээс олоорой**

Танд тохирох ажлын байрыг
хурдан, оновчтой санал болгоно



- 01 Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэг
- 02 Малчдыг малжуулах
- 03 Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг
- 04 Түрээсийн дэмжлэг үзүүлэх
- 05 Борлуулалтын дэмжлэг үзүүлэх
- 06 Ажил олгогчийг дэмжих
- 07 Хүүхэд харах төвд түрээсийн болон бусад дэмжлэг үзүүлэх

САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХАМРАХ ХҮРЭЭ

- Ажилгүй иргэн
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн

ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Хан-Уул дүүргийн иргэн байх
- 30-с дээш насны хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн
- Өөрийн эзэмшсэн мэргэжлийн дагуу үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт ирүүлсэн бол давуу тал болно.
- Эргэн төлөлтөө бүрэн барагдуулах тооцоолол, чадамжтай байх
- Хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ буюу профайлинг хийлгэх

ОЛГОХ САНХҮҮГИЙН ХЭМЖЭЭ:

10.000.000 / 10 сая хүртэл/

Санхүүгийн нөхцөл: 100 % эргэн төлөгдөх нөхцөлтэй

- 01 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээ
- 02 Санхүүгийн дэмжлэг
- 03 Аж ахуй эрхлэлтийн сургалт
- 04 Хөдөлмөр эрхлэлтийн сургалт
- 05 Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг
- 06 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ажлын байр бий болгосон ажил олгогчид үзүүлэх дэмжлэг
- 07 Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаа

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХАМРАХ ХҮРЭЭ

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
- Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ асардаг иргэн

ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Хан-Уул дүүргийн иргэн байх
- Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хүчинтэй шийдвэрийн хуулбар /Хугацаа дуусаагүй байх/
- Өөрийн эзэмшсэн мэргэжилийн дагуу үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт ирүүлсэн бол давуу тал болно.
- Эргэн төлөлтөө бүрэн барагдуулах тооцоолол, чадамтай байх

ОЛГОХ САНХҮҮГИЙН ХЭМЖЭЭ:

5.000.000-10.000.000 / таван сая төгрөгөөс арван сая төгрөг хүртэл/

Санхүүгийн нөхцөл: 50 % эргэн төлөгдөх нөхцөлтэй

05

ТҮР АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

01

Ахмад мэргэжилтний
зөвлөх үйлчилгээ

04

Ажилд зуучлах

02

Нийтийг хамарсан ажил

05

Хүүхэд хамгаалагч үйлчилгээ

03

Ахмадын төрийн бус
байгууллагын зөвлөх үйлчилгээ

06

ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОДОРХОЙЛСОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

01

Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төслийг
боловсронгуй болгож хэрэгжүүлэх

02

Ажил олоход хүндрэлтэй иргэнийг тогтмол ажлын байраар
хангасан аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг үзүүлэх

03

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг
ажил олгогчид дагалдуулан суралцуулахад дэмжлэг үзүүлэх

04

Өмнөх мэдлэг, ур чадварын үнэлгээ зохион байгуулах

05

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн
судалгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах

06

Хохирогчийг ажлын байраар хангах,
мэргэжлийн сургалтанд хамруулах

07

Бусад



Хаанаас ч хэзээ ч
анкетаа үүсгэх



Канбан самбараар
бүрэн хянах



Ажилд горилох хүсэлтээ
нэг товшилтоор илгээх



20 үзүүлэлтийг
үндэслэсэн ажлын байрыг
автоматаар санал болгоно

БҮРТГҮҮЛЭХ






7731-5091



www.ejob.gov.mn

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН 69 ТӨРЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЦАХИМД ШИЛЖСЭН

10 төрөл

Олон нийтийн оролцоонд
түшиглэсэн халамжийн үйлчилгээ

17 төрөл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд
үзүүлэх тусламж, хөнгөлөлт

4 төрөл

Асаргааны тэтгэмж

16 төрөл

Ахмад настанд үзүүлэх
дэмжлэг, хөнгөлөлт

2 төрөл

Амьжиргааг дэмжих
мөнгөн тэтгэмж

3 төрөл

Алдар цолтон ахмад настанд
үзүүлэх тусламж, хөнгөлөлт

4 төрөл

Онцгой тохиолдлын
мөнгөн тэтгэмж

1 төрөл

0-3 хүртэлх насны хүүхэд
асарсны тэтгэмж

1 төрөл

Ихэр хүүхдийн тэтгэмж

1 төрөл

0-18 хүртэлх насны 3 болон түүнээс дээш
хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж

1 төрөл

Насны хишиг

1 төрөл

Алдарт эхийн
одонгийн тэтгэмж

5 төрөл

Нийгмийн халамжийн тэтгэвэр

1 төрөл

Хүүхдийн мөнгөн хуримтлал

1 төрөл

Жирэмсэн эхийн тэтгэмж

ЖИРЭМСЭН ЭХИЙН ТЭТГЭМЖ

Эхэд жирэмсний 5 сартайгаас төрөх хүртэлх хугацаанд Засгийн газраас
тогтоосон хэмжээгээр сар бүр тэтгэмж олгоно

Өрхийн эмнэлгийн
үзлэгт хамрагдана



Ehalmj.mn-д нэвтэрч,
цахимаар хүсэлтээ
гаргана



Халамжийн тэтгэмжийн
мөнгөө авах өөрийн
арилжааны банкны дансны
дугаарыг системд бүртгүүлнэ



Нийгмийн халамжийн
мэргэжилтэн цахимаар
ирүүлсэн хүсэлтийг
хянаж шийдвэрлэнэ



Халамжийн тэтгэмж нь
иргэний бүртгүүлсэн банкны
харилцах дансанд орно



НАСНЫ ХИШИГ, ЭХ ОЛОН ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ, ЭЦЭГТ ОЛГОХ ТЭТГЭМЖ

“Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.1-д дараах тэтгэмжүүдийг олгохоор зохицуулсан.

Ehalamj.mn-д нэвтэрч,
цахимаар хүсэлтээ
гаргана.



Өөрийн халамжийн
тэтгэмж авах арилжааны
банкны дансны дугаараа
системд бүртгүүлнэ



Нийгмийн халамжийн
мэргэжилтэн цахимаар
ирсэн хүсэлтийг
шийдвэрлэнэ



Амьжиргаа дэмжих
зөвлөлийн хурлын
шийдвэрийг оруулна.
Өрх толгойлсон эцэг,
эхийн тэтгэмж



Халамжийн тэтгэмж нь
иргэний бүртгэсэн
банкны харилцах
дансанд орно.



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

01

0-3 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭД АСАРСНЫ ТЭТГЭМЖ

0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх/эцэг/-т Засгийн газраас тогтоосон хэмжээгээр сар бүр тэтгэмж олгоно.

Өрхийн эрүүл мэндийн төвд хандаж, хүүхэд эсэн мэнд бойжиж байгаа тухай эрүүл мэндийн цахим системд бүртгүүлнэ.

0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид эцэг хамрагдах тохиолдолд эцэгт тэтгэмж олгохыг зөвшөөрсөн тухай нотариатаар батлуулсан эхийн хүсэлтийг зааврын дагуу цахим хэлбэрт хөрвүүлж, системд байршуулна.



02

ИХЭР ХҮҮХДИЙН ТЭТГЭМЖ

Засгийн газраас тогтоосон хэмжээгээр 2 ба түүнээс дээш ихэр хүүхдэд нэг удаа тэтгэмж олгоно.

Өрхийн эрүүл мэндийн төвд хандаж, хүүхэд эсэн мэнд бойжиж байгаа тухай эрүүл мэндийн цахим системд бүртгүүлнэ.



03

ГУРАВ БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ, ЭЦГИЙН ТЭТГЭМЖ

0-18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү хэмжээний тэтгэмжийг улирал бүр олгоно.



ОНЦГОЙ ТОХИОЛДЛЫН МӨНГӨН ТЭТГЭМЖ

Дараах иргэнд Засгийн газраас тогтоосон хэмжээгээр нэг удаа тэтгэмж олгоно



01

Гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх



02

18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн



03

Хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай гишүүн-иргэн



04

Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн дөрөв түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг эх

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэвэр авах эрх үүсээгүй иргэнд Засгийн газраас тогтоосон хэмжээгээр сар бүр тэтгэмж олгоно.

01

**Эрэгтэй 60, эмэгтэй 55
болон түүнээс дээш настай
иргэн**



02

16 насанд хүрсэн одой иргэн



03

**Хөдөлмөрийн чадвараа 50 ба
түүнээс дээш хувиар алдсан 16
насанд хүрсэн хөгжлийн
бэрхшээлтэй иргэн**



04

**Тэжээгч нь нас барсан 18
хүртэлх насны хүүхэд**



05

**18 хүртэлх насны дөрөв ба
түүнээс дээш хүүхэдтэй, өрх
толгойлсон 45 насанд хүрсэн
эх, 50 насанд хүрсэн эцэг**

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Дараах иргэнд Засгийн газраас тогтоосон хэмжээгээр нэг удаа тэтгэмж олгоно



01

АМЬЖИРГААГ ДЭМЖИХ МӨНГӨН ТЭТГЭМЖ

Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхдэд Засгийн газраас тогтоосон тухай үеийн нийгмийн халамжийн тэтгэвэртэй тэнцүү хэмжээний тусламжийг сар бүр олгоно. Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэнд улиралд Засгийн газраас тогтоосон хэмжээгээр тэтгэмж олгоно.



02

АХМАД НАСТАНД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ, ХӨНГӨЛӨЛТ

Ахмад настан: 60, түүнээс дээш настай эрэгтэй, 55, түүнээс дээш настай эмэгтэй хамаарна.

65 болон түүнээс дээш настай ахмад настанд Цагаан сар, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан Насны хишгийг жилд 2 удаа олгоно



03

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТ

0-16 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс 16 ба түүнээс дээш насны хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс тодорхойлно




04

ХҮНС ТЭЖЭЭЛИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Хүнсний эрхийн бичиг олгох” нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд хүнсний эрхийн бичиг олгох босго оноог орон нутагт 310.0, нийслэлд 292.5 ба түүнээс доош байгаа өрхийн гишүүн-иргэнд сард олгох хүнсний эрхийн бичгийн үнийн дүнг Төрийн захиргааны төв байгууллага (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд) –ын тушаалаар тогтоож олгоно.

Өрхийн амьжиргааны түвшингээ үнэлүүлж, өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон байна.



ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- ✖ Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөлд хамруулах, амьдрах ухаанд сургах үйлчилгээний Бүлгийн төсөлд хамрагдах боломжтой.
- ✖ Бүлгийн гишүүд (2-3 зорилтот өрх, иргэн) сайн дурын үндсэн дээр нэгдэж өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг байна.
- ✖ Бүлгийн төслийг хүний нөөц, зах зээлийн болон эдийн засгийн тооцоо, судалгаа, төлөвлөгөөтэй боловсруулна.
- ✖ Нэг өрхийн гишүүд тус тусдаа бүлгийн төсөлд хамрагдаж санхүүжилт авахыг хориглоно.
- ✖ Бүлгийн төслийн санхүүжилт авсан иргэн 3 жилийн дотор дахин хамрагдахгүй.
- ✖ Бүлгийн төсөлд олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг ХХҮЕГ-ын даргын тушаалаар батална. Санхүүгийн дэмжлэг нь буцалтгүй байна.


Өргөдөл

Цахимаар хүсэлт гаргах боломжгүй бол оршин суугаа хорооны Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнд өөрийн биеэр хандаж хүсэлт гаргана.

ХҮҮХДИЙН
МӨНГӨН

ТЭТГЭМЖ

Монгол Улсын 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт



БҮРТГҮҮЛЭХ

